



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/648

Булган сум

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг
сурталчлах ажилд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах шторк бэлтгэх ажилд “Баздаг хөл” ТББ-ын Тэргүүн Б.Бямбацогттой гэрээ байгуулан ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал)-д үүрэг болгосугай.

2.Гэрээний үнэ 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын 2025 оны хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээ хэрэгжүүлэх зардлын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР